


**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮРЭЭНД 2020 ОНД АВЛИГА, ГЭМТ
ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2020.01.15

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
Нэг. Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх, ёс зүйг дээшлүүлэх		
1	Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд нээлттэй болгох, байгууллагын вэб сайтад байршуулах	2020 онд Хувийн ашиг сонирхлын урьдчилан мэдүүлэг /ХАСУМ/-ийг хянуулахаар албан тушаалтан томилогдоогүй байна.
2	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах.	2020 онд Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, бүртгэж хянаж хуулийн хугацаанд 1 албан хаагчийн материалыг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэлийг дэвтэрт цаг тухайд нь хөтлөн ажиллаж, АТГ-ын ЭБАТ-ын эрхээр тайлангаа шивж хуулийн хугацаанд төв ЭБАТ-д бичмэл тайланг гаргаж хүргүүлэн ажилласан. Эрүүл мэндийн газрын 2 төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг аймгийн Засаг даргын захирамжийн дагуу нэмэгдүүлсэн. Үүнд: Дэд болон Гутгаар зэрэг төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдлийг олгож ажилласан байна.
3	Төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг байгууллагын вэб сайтанд ил тод, нээлттэй байршуулах.	Эрүүл мэндийн газар нь аймгийн Засаг даргын 2019 оны А/413 дугаар захирамжаар 36 орон тоотой ажиллахаас 2020 онд 29 албан хаагчтай ажиллаж дутагдалтай сул орон тоонд албан тушаалын тодорхойлолтоор мэргэжлийн шаардлага хангасан их эмч 1, эрүүл мэндийн нийгмийн ажилтан 3, эрүүл ахуйч 1, хоол зүйч 1 тус тус Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 01 дүгээр зөвлөмжөөр гэрээ байгуулан ажиллалаа. Төрийн захиргааны албан тушаалын 12, төрийн үйлчилгээний 1 сул орон тооны мэдээллийг Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн Хөдөлмөрийн бирж болон салбар Эрүүл мэндийн байгууллагууд, Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудсанд нээлттэй ажлын байр зарласнаар Төрийн албаны тусгай шалгалтаар 1 иргэн ажлын байранд томилогдож, ерөнхий шалгалтад 8 их эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэн тэнцэн нөөцөд бүртгэгдсэн. Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны албан тушаалын 12 сул орон тоонд тусгай шалгалт зохион байгуулах саналаа Орхон аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн. Тайлант онд 1 төрийн захиргааны албан хаагч өндөр насны тэтгэвэрт, өөрийн хүсэлтээр 1 албан хаагч нөр төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн.




Эрүүл мэндийн салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагуудын ил, тод байдлыг ханган ажиллах.

Орхон аймагт 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн салбарт нийт 160 эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагад 1692 эмч, эмнэлгийн мэргэжилтэн ажиллаж байна. Үүнээс: Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Жаргалант сумын эрүүл мэндийн төв, Өрхийн эрүүл мэндийн төв 8, амбулаторын тусламж үйлчилгээ үзүүлэх клиник 56, амбулаторын болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээг 13 эмнэлэг, эм ханган нийлүүлэх байгууллага 13, эмийн сан 66 тус тус ажиллаж байна. Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй эмийн сан 66, амбулаторын тусламж үйлчилгээ үзүүлэх 56, хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлэх 13 эмнэлгийн хаяг, байршил, холбогдох утасны дугаар, бусад мэдээллийг байгууллагын www.or.mohs.gov.mn-д байршуулан иргэд, олон нийтэд мэдээлж ил тод байдлыг хангаж ажиллаж байна.






4	<p>Төрийн албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг холбогдох журмын дагуу албан тушаал бүрээр боловсруулан баталж мөрдүүлэх.</p>	<p>Эрүүл мэндийн газар аймгийн Засаг даргын 2019 оны “Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тоог батлах тухай” А/413 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган төрийн захиргааны 24 албан хаагч, төрийн үйлчилгээний 12 албан хаагч, нийт 36 орон тоотой ажилласан.</p> <p>Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын Б/04 дүгээр тушаалаар “Ажлын хэсэг” байгуулж, Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны албан хаагчдын ажлын байранд чиг үүргийн шинжилгээ хийж 23 төрийн захиргааны албан хаагчийн ажлын байранд хууль тогтоомжоор заасан үндсэн болон дэд, туслах чиг үүргийг тодорхойлж, ажлын байрны шинжилгээг хийсэн. Ажлын байрны шинжилгээн дээр үндэслэн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 37 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, тус газрын төрийн захиргааны 23 албан тушаалтны тодорхойлолтыг “Зөвшөөрөл олгох тухай” 149 дүгээр тогтоолоор ТЗ-5 ангилал зэрэглэлээр батлах зөвшөөрөл олгосон. Уг тогтоолын дагуу Эрүүл мэндийн газрын даргын 2019 оны А/76 дугаар тушаалаар Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны 23 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг албан тушаал бүрээр баталж, байгууллагын албан хаагчдад танилцуулан тушаалын хэрэгжилтийг ханган ажиллалаа. Мөн тус газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 63 дугаар тогтоолын дагуу аймгийн Засаг дарга 2019 оны “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай” А/704 дүгээр захирамжийг баталж ирүүлсэнийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Дээрх тогтоолоор тус газрын Төрийн захиргааны 23 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг дэс түшмэлийн ТЗ-5 ангилалд ажиллахаар баталсан тул ЭМГ-ын даргын 2019 оны Б/45 тушаалаар ТЗ-7 ангилалд ажиллаж байсан 4 албан хаагчийг ТЗ-5 ангилалд шилжүүлэн томилсон.</p>
5	<p>Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн зөрчил, өргөдөл, гомдлыг судалж тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх.</p>	<p>Нийт эрүүл мэндийн ажилтны 53,8%-ийг сургалтад хамруулсан байна. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаа, хандлагыг сайжруулах, ёс зүйн алдаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 36 удаагийн сургалт зохион байгуулж, 678 эмнэлгийн ажилтан 1623 үйлчлүүлэгчийг хамруулсан нь өмнөх оноос үйлчлүүлэгчийн хамралт 4.1 дахин нэмэгдсэн байна. - Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах чиглэлээр 81 албан

		<p>хаагчийг сургалтад хамруулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Коронавируст /ковид 19/ халдварын үеийн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад нийт 120 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулсан. - Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос эмч, эмнэлгийн ажилчдын нэр хүндийг өсгөх чиглэлээр Дэлхийн эмч нарын баярыг угтан “Эмч тандаа баярлалаа”, Олон улсын сувилагчдын өдрийг угтан “Сувилагч тандаа баярлалаа” цахим талархлын аяныг зохион байгуулсан. Шинэ коронавирусийн халдвар (COVID-19)-ын үед иргэнийг тусгаарлах, ажиглах тур журмын дагуу тусгаарлах, ажиглах байранд эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа эмч, эрүүл мэндийн ажилтнуудыг алдаршуулан “Эх орон биднийг дуудсан” цахим талархлын аян зохион байгуулсан. <p>Тайлант хугацаанд Эрүүл мэндийн газарт ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад талархал 5%-аар өсч, гомдол 2,1 дахин буурсан үзүүлэлттэй байна</p>
6	Төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах.	<p>2020 онд Эрүүл мэндийн салбарт Улс болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 3 тэрбум 341,7 сая төгрөгийн нээлттэй тендерыг зарлан холбогдох хууль журмын дагуу компани шалгарч 100 хувь гүйцэтгэлтэй нийлүүлэгдсэн. Мөн Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн эмийн зардалд 1 тэрбум 850,0 сая төгрөгийн 38 багц дээр нээлттэй тендер зарлан гүйцэтгэгч компаниуд шалгарч “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу 100 хувь нийлүүлэгдсэн.</p> <p>Сангийн сайдын 2018 онд батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын дагуу тайлант хугацаанд хийгдсэн худалдан авах ажиллагааны тайланг ЭМЯ болон орон нутгийн өмчийн газар тайлагнан ажилладаг.</p>
1	Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг ёс зүйн болон соён гэгээрүүлэхэд чиглэсэн шторк, мэдээ, мэдээллийг нийт ажилтан, албан хаагчдад тогтмол хүргэж хэвших.	<p>Хоёр. Соён гэгээрүүлэх ажлын хүрээнд</p> <p>Эрүүл мэндийн салбарын хэмжээнд “авлигын эсрэг” сарын аяныг 2020.09.01-нээс 30 хоногийн сарын аяныг зохион байгуулан ажиллаа.</p> <p>Эрүүл мэндийн газрын fb хуудас болон сайтад шторкуудыг байршуулж нийт 150 гаруй хандалтыг авсан байна. Мөн ЭМГ албан хаагчид болон Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг сурталчилан таниулан ажиллаа.</p> <p>Сургалтанд нийт 25 албан хаагчид сургалтанд хамрагдаж Эрүүгийн хуульд авлига албан тушаалын гэмт хэргийг тусгасан шинэчлэгдсэн хуулийн заалтуудыг танилцуулан ажиллаа.</p> 




Сурталчилгааны чиглэлээр: Мэдээллийн самбар болон зурагт хуудсаар ШТОРК-ыг явуулж нийт 15 удаагийн давталттайгаар явуулсан.





Мөн Авлигатай тэмцэх газрын Нийтийн албан тушаалтны зүгээс гаргаж байгаа ашиг сонирхлын нийтлэг зөрчил, анхаарах асуудал, албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгах үндэслэл, хариуцлагын төрөл, анхаарах асуудал, зөрчил дутагдлын талаар харандааны зураглалаар хийгдсэн 3 төрлийн шторк, сурталчилгаа /зохиомжит промо/-г АТГ-ын www.iaac.mn цахим хуудсанд байршуулсныг татан авч Эрүүл мэндийн газрын цахим хуудас болон БОЭТ, Медипас, Жаргалант сумын ЭМТ, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн цахим хуудас, сурталчилгааны дэлгэцээр тогтмол явуулж нийт 30 удаагийн давтамжтайгаар явуулсан.







2 Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт авлигын эсрэг хууль, тогтоомж, зөвлөмж, сайн туршлагыг байршуулах, сурталчилах.


Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт авлигын эсрэг хууль тогтоомж болон мэдээллийн самбарт байршуулж Эрүүл мэндийн яам болон Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийг эрүүл мэндийн салбарын хэмжээнд танилцуулан мөрдөж ажиллаж байна. ЭМГ-ын пейж хуудас болон og.mohs.gov.mn сайт, БОЭТ цахим сүлжээ болон WWW.ORKHONBOET.mn/ сайт, мэдээллийн самбар, дотоод сүлжээндээ тогтмол байршуулан ил тод нээлттэй байршуулан ажилласан.



Хэвлэмэл хуудсуудыг олон нийтийн газарт байршуулан, иргэдэд сурталчилан таниулан ажилласан. Алслагдсан өрхийн эмнэлэгүүд 12 дэлгүүр, 11 худаг, 6 автобусны буудал болон багийн байруудад байршуулж эмч, сувилагч нарт авлигын эсрэг хууь болон Эрүүгийн хуульд авлигын хэлбэрийг хэрхэн хуульчилсан талаарх мэдээллийг өгч ажиллаа. Уг сурталчилгааны 200 ширхэг материалиудыг иргэдэд сурталчилан таниулан тарааж ажилласан.





		
3	<p>Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон тэдэнд үйлчилгээ үзүүлж буй бүх түвшний мэргэжлийн болон захиргааны байгууллага, албан тушаалтнуудад зориулсан урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулах</p>	<p>Орхон аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт 3273 хүн байна. Хөгжлийн бэрхшээлтэй 388 хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлсэн. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс”-ын үйл ажиллагаа тогтмолжсон бөгөөд тайлант хугацаанд 407 хүүхдийн асуудлыг шийдвэрлэсэн байна.</p> <p>Зорилтот бүлгийн 12-18 насны 45 охин, 10 асран хамгаалагчийг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж, 12 охиныг эмчилгээнд хамруулан эрүүлжүүлсэн. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндийн асуудалд шийдвэр гаргах түвшний оролцоо” салбар дундын өргөтгөсөн хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ-аас санхүүжүүлж зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрүүл мэндэд тулгамдаж буй асуудлыг 0-16 насны хүүхэд, насанд хүрэгчдийн төрлөөр ангилан хэлэлцэж, шийдвэрлэсэн. Ерөнхий боловсролын сургуульд 129, цэцэрлэгт 28 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагдсан. 2020 оны 11 дүгээр сарын 1-ээс 27-р цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй 30 хүүхдийн 2 анги нээгдсэн. Тайлант хугацаанд 7-р сургуулийн тусгай хэрэгцээт боловсролын багшлах боловсон хүчнийг чадваржуулахаар Дауны болон Аутизмын холбоодын сургалтад хамруулан чадавхжуулсан.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тусгай хэрэгцээг хангах, хөгжих боловсрох, эмнэлгийн тусламж авах нөхцөлийг хангах, гэрийн асаргаа сувилгааг сайжруулах чиглэлээр 78 сая төгрөгийн төсөв орон нутгийн төсвөөс батлагдан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асран хамгаалж буй эцэг эхчүүдийн нийгмийн халамжийн төлөлтийг санхүүжүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуусыг сэргээн засах, хөгжүүлэх чиглэлээр 8 төрийн бус байгууллагын Найдвар төв, Сэтгэл заслын төв, Пондолой аутизмын төв, хүүхэд залуучуудын өдөр өнжүүлэх төвүүдтэй гэрээ хийн орон нутгийн сангаас 183 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэсэн. Тус төвүүдийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудад насны ангиллаар төрөлжсөн үйлчилгээг хүргэх чиглэл өгч ажиллуулсан ба нийтдээ 50-60 хүүхэд үйлчилж, үйл ажиллагаа явуулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг үнэмлэхжүүлэх ажилд 2.3 сая төгрөгийг орон нутгийн сангаас гаргасан. Тайлант хугацаанд 78 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асран хамгаалагчдын сайн дурын болон эрүүл мэндийн даатгалд 55.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон.</p> <p>Аймгийн Засаг даргын 2020 оны А/754 дүгээр захирамжаар 13.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж Орхон аймгийн хөгжлийн бэрхшээлтэй зорилтот бүлгийн 18 багийн 200 хүүхдэд дархлаатуулалтын багцаар ханган ажиллаа.</p>



4 Төрийн албаны шинэтгэл, дагалдан гарсан дүрэм журмын танилцуулгыг хийж сургалтыг зохион байгуулах.

Орхон аймгийн төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд төрийн захиргааны албан хаагчдын саналыг авч, төрийн албаны богино хугацааны сургалтад суралцах албан хаагчдын судалгааг хүргүүлсэн. Удирдлагын академиас зохион байгуулж байгаа ахлах түшмэлийн сургалтад 1, төрийн албан хаагчийг чадавхжуулах сургалтад 1 мэргэжилтэн цахимаар, Төрийн албаны салбар зөвлөлөөс зохион байгуулсан “Удирдах ажилтны ёс зүй, манлайлал”, “Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй” сургалтад тус бүр 2 мэргэжилтэн хамрагдаж гэрчилгээ авсан.



Гурав. Хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх ажлын хүрээнд

1 Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг тухай бүр хуулийн хугацаанд нь гарган хэрэгжүүлэн ажилласан. Доорх линкээр хэрэгжилтийг хянан ажилласан. <https://shilendans.gov.mn/org/1417?group=0&year=2020>

2 Байгууллагын дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх, хяналт шалгалтын ажлыг төлөвлөх, дүнг мэдээлэх, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээг авч ажиллах /дүгнэлт, зөвлөмж, шийдвэр г.м/

Санхүүгийн дотоод хяналт, аудитын албанаас өгсөн албан шаардлагын дагуу Дотоод хяналтын баг, ажиллах журмыг шинэчлэн, Эрүүл мэндийн газрын даргын А/36 дугаар тушаалаар батлуулж, төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Дотоод хяналтын төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна. Дотоод хяналтын баг 4 удаа хуралдаж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт хийгдэж байгаа байдлыг хэлэлцэн гишүүдийг үүрэгжүүлж, хяналтын дүгнэлт, зөвлөмж дээр санал солилцон, шийдвэрийг гарган ажилласан. Тайлант хугацаанд төлөвлөгөөт 12, төлөвлөгөөт бус 2 хяналтыг хийсэн

		<p>Тайлант хугацаанд Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн улирлын төлөвлөгөөний хэрэгжилт болон 2 өрхийн эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын багийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хийж, зөвлөмжөөр хангасан. Коронавируст халдварын цар тахалтай холбогдуулан өрхийн эрүүл мэндийн төвүүд, БОЭТ-д коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын хариу арга хэмжээний бэлэн байдал, эмнэлгийн тусламж үйлчилгээний зохион байгуулалт, эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдал, хүний нөөцийн төлөвлөлт, эрх зүйн хэрэгжилтэд хяналт хийж зөвлөмжөөр хангасан.</p> <p><u>БОЭТ</u>, хувийн хэвшлийн ортой эмнэлгүүд, Эрдэнэт сувиллын цогцолбор, Эм ханган нийлүүлэх байгууллага сум, өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 31 байгууллагын гэрээний төслийг хянаж, гэрээг байгуулсан.</p>
3	<p>Эрүүл мэндийн салбарт Гадаадын зээл тусламж, төсөл хөтөлбөрөөр хийгдэж буй арга хэмжээ бүрийн гүйцэтгэлийн явц, тайланг нээлттэй ил тод болгох</p>	<p>Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр хэрэгжиж буй гадаадын зээл тусламж, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөр дараах чиглэлээр хэрэгжиж байна. Үүнд:</p> <p>1. Глобал сан “Сүрьеэгийн тохиолдлыг эрт илрүүлэх дадлыг дэмжих замаар үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, өвчтөн төвтэй нэгдсэн халамж үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажиллагааг бүрдүүлж хэвшүүлэх, эмийн дасалттай сүрьеэгийн аюулд анхаарах” төслийн хүрээнд <u>ДОХ/Сүрьеэгийн төсөл</u> 2018 оноос 2020 он хүртэл үргэлжлэн ажиллаж байна. 2020 оны байдлаар аймгийн хэмжээнд <u>Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн</u> 8 эрүүл мэндийн сайн дурын идэвхтэн ажиллаж байгаа ба 34 өвчтөний эмчилгээг гэрээр хянан эмийг өдөр бүр харж уулган, сайн дурын 5 идэвхтэн эрт илрүүлгийн асуумж судалгаа авч эмч, мэргэжилтнүүдийн ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан. <u>Глобал сангаас</u> 2020 онд эмийн зардалд 63,0 сая төгрөг, буцалтгүй тусламж 472,0 мянган төгрөг, сайн дурын идэвхитний унааны зардалд 7,8 сая төгрөгийг санхүүжүүлэн ажилласан.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p>2. БОЭТ-ийн ЭМЯ, ЭМХТ, Жайка Японы олон улсын ХАБ-ын “Монгол Улсын анхан болон хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Ерөнхий мэргэшил судлал” үндсэн мэргэшлийн 2 дахь жилийн сургалтад Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/456, А/457 тоот тушаалаар 5 суралцагч эмч элсэн суралцаж байна. 2020 оны 11 сараас БОЭТ нь Ерөнхий мэргэшил судлалын 3 дах жилийн сургалтад 3 резидент эмчийг элсүүлэн сургалтыг үргэлжлүүлэн амжилттай зохион байгуулж байна. БОЭТ-ийн захирлын тушаалаар томилогдсон “Төгсөлтийн дараах сургалтын хяналтын зөвлөл” ажиллаж ерөнхий мэргэшил судлалын сургалтын журам, хөтөлбөр, төлөвлөгөө, хуваарийг хэлэлцэн батлан, төгсөлтийн дараах сургалтын хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан. Сургалтад хэрэглэх сургалтын материалуудыг</p>

ЖАЙКА, Японы Олон Улсын Эрүүл Мэнд Анагаах Ухааны Үндэсний Төвийн олон улсын эрүүл мэндийн хамтын ажиллагааны газрын хүүхдийн болон эх барих эмэгтэйчүүдийн эмч нар, GENEPRO байгууллагатай хамтран боловсруулж, ЭМЯ-ны харьяа салбар мэргэжлийн зөвлөлөөр тус, тус батлуулан тойролтын гарын авлагыг боловсруулж сургалтад хэрэглэгдсэн. Аймгийн Засаг даргын 2020 оны А/215 дугаар захирамжаар анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах үйл ажиллагааны хүрээнд “Эх барих эмэгтэйчүүд”, “Хүүхэд судлал” эрүүл мэндийн бүтээлийг анхан шатлалын эмнэлгийн мэргэжилтний өврийн ном болгон хэвлүүлэхэд 3,0 сая төгрөг шийдвэрлэгдэж, тус бүр 100 ширхэг хэвлэгдэн, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн болон БОЭТ-ийн эмч нарт түгээгдэн ашиглагдаж байна.



3.Люксембүргийн вант улсын хөгжлийн агентлаг “Зүрх судасны төв, эх нярайн эрүүл мэнд ба цахим эрүүл мэндийн өргөжил” төслийн хүрээнд цахим өвчний түүхээр онош эмчилгээний зөвлөгөө авах шаардлагатай 21 хүний мэдээллийг алсын зайн сүлжээгээр дамжуулж оношилгоо, эмчилгээний зөвлөмж авсан. Төсөл хэрэгжих хугацаанд 91 удаагийн хэлэлцүүлэгт оролцсон. Зүрх судасны үндэсний mn.Cardio программын цахим өвчний түүхэнд 2192 хүний мэдээллийг оруулсан.

Зүрх судасны эмч нар цахимд байрлуулсан мэргэжлийн зайн сургалтанд тогтмол хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлж, багц цаг бүрдүүлсэн. MnCardio программын сургалт, шинэчлэгдэн батлагдсан заавар удирдамжуудыг хэрэгжүүлэх сургалтыг Судасны багаас хийж, титэм судсан дотуурхи эмчилгээний дараахь, зүрхний шигдээсийн дараахь хяналтын үзлэг, зүрхний эхо, зүрхний ишемитэй судсан дотуурхи оношилгоо эмчилгээ шийдүүлэх, захын судасны эмгэгтэй хүмүүст үзлэг хийн зөвлөгөө өгч шийдвэрлэсэн.

Улсын клиникийн гуравдугаар эмнэлгийн Зүрх судасны төвөөс Пүрэв гараг бүр зохиож байгаа Zoom Online сургалтад эмч нар хамрагдаж, мэдлэгийг дээшлүүлсэн.



Оношлогооны шинэ багаж тоног төхөөрөмжөөр хангагдсанаар эмчилгээ, оношлогооны чанарт дэвшил гарсан. Тухайлбал зүрхний хэт авиан шинжилгээгээр нярайн хавсарсан хүнд гажигууд болон констриктив перикардит, аортын аневризм, бактериальны эндокардит, тромбо миксома зэрэг ховор тохиолдлуудыг амжилттай оношилж 625 хүний эмчилгээний асуудлыг шийдвэрлэсэн. Мөн холтер ЗЦБ, ачаалалтай ЗЦБ, холтер даралт хэмжих аппаратуудаар зүрхний хэм алдагдал, далд ишемийг илрүүлэн оношлогоо, эмчилгээнд ахиц гаргалаа.


Дээд шатлалын эмнэлэгт оновчтой шилжүүлэг нэмэгдэж, үр дүн нь сайжирсан. Зүрхний ишеми, инфаркттай 21 хүнийг оновчтой цаг хугацаанд нь коронарангиографийн шинжилгээнд илгээж, судсан дотуурх эмчилгээг хийлгэсэн. Төрөлхийн гажигтай 5 хүнийг хагалгаа хийлгэсэн. Олдмол гажигтай 2 хүнийг хавхлага солих хагалгаанд оруулсан. Мөн хэм алдагдлын хүнд хэлбэртэй өвчтөнд пейсмеркер эмчилгээ, захын судасны бөглөрөлтэй хүнд эрсдэлтэй өвчтөнг цаг хугацаанд нь илгээж судасны мэс засал хийлгэж эмчилгээний үр дүн сайн байна.

4 Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг бүх хэлбэрээр авч, шийдвэрлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, мэдээлэх

Тайлант хугацаанд эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой цахимаар 116, бичгээр 44, биечлэн уулзаж 6 гээд нийт 166 хүсэлт, талархал гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд нь иргэдэд хүлээлт чирэгдэл үүсгэлгүйгээр шийдвэрлэсэн. Нийт ирүүлсэн өргөдөл, хүсэлт, талархал гомдлын 63.8%-ийг хүсэлт, 8.4%-ийг гомдол, 27,8%-ийг талархал тус тус эзэлж байна. Эрүүл мэндийн газарт ирүүлсэн хүсэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад талархал 5%-иар өсч, гомдол 2,1 дахин буурсан үзүүлэлттэй байна. Өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн мэдээлэл АЗДТГ-ын шуурхай хурал, erdenet.mn, 70353511 дугаарт утсанд бүртгэгдэж мэдээлэгдэж байгаад иргэд талархалтай хүлээн авч байна. Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn цахим хуудсанд байршуулж ил тод байдлыг ханган ажилласан.

5 Аж ахуйн нэгж байгууллага болон иргэдээс хандив зээл тусламжаар ирсэн бэлэн мөнгө болон бараа материалын ил тод нээлттэй байдлыг ханган хэрэгжилтийг тайлагнан ажиллах.

2020 онд Эрүүл мэндийн салбарт нийт 15 байгууллага иргэнээс 7,0 сая төгрөгийн бараа материал болон хамгаалах хувцас, Чандмана Эрдэнэ Холбооноос 5,7 сая төгрөгийн бэлэн мөнгө тус тус хандивласан. Дээрх хандивласан бараа материалын Эрүүл мэндийн газрын www.or.mohs.gov.mn сайт болон ЭМГ-ын пейж хуудсанд тухай бүр тавьж ажилласан. Мөн орлогод авч зарцуулалт хийж тайлан балансанд тусган ил тод байдлыг ханган ажиллааа.



БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ЭДИЙН ЗАСАГЧ Д.ОТГОНДЭЛГЭР